



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

(2011 оны нэгдүгээр улирал)

Танилцсан:

ХОРООНЫ ДАРГА	Д.БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б.ШАРАВСАМБУУ
ХОРООНЫ ГИШҮҮН	Д.ДҮГЭРЖАВ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х.БУМ-ЭРДЭНЭ

Хянасан:

БСГ-ЫН ДАРГА	Н.ОЮУНЧИМЭГ
БСГ-ЫН ОРЛОГЧ ДАРГА	Б.ДОЛГОРСҮРЭН

Боловсруулсан:

БСГ-ЫН АХЛАХ ХЯНАН ШАЛГАГЧ	Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
----------------------------	---------------

**Улаанбаатар хот
2011.05.03**

ГАРЧИГ

I. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

II. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд
- Хасбанкны франчайзийн гэрээтэй ажиллаж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

III. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- Орлогын үзүүлэлтүүд
- Зардлын үзүүлэлтүүд
- Алдагдалтай ажиллаж буй хоршоод
- Ашигтай ажиллаж буй хоршоод

IV. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- Активын чанар
- Зээлийн багцын чанар

V. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

VI. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

VII. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР

VIII. ДҮГНЭЛТ

IX. ХАВСРАЛТ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХОРШООДЫН 2011 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2011.05.03

Улаанбаатар хот


НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Хорооны хуралдаанаар тайлант улиралд 2 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 3 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 2 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 8 хоршооны тусгай зөвшөөрлийг сунгахаар шийдвэрлэж 2011 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 178 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлж байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэж буй хоршоодоос 155 буюу нийт хоршооны 87.1 хувь нь зохих журмын дагуу 2011 оны нэгдүгээр улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 23 буюу 12.9 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээг хугацаанд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүйгээс, тэдгээр хоршоодын Хороонд ирүүлсэн сүүлийн улирлын санхүүгийн тайлангаар нэгтгэлд хамрууллаа.

Санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлсэн 155 хоршооны тайлан мэдээг ирүүлсэн хугацаагаар нь авч үзвэл журмын дагуу хугацаандаа ирүүлсэн 73 хоршоо, 10 хүртэл хоног хоцроосон 66 хоршоо, 11-20 хүртэл хоног хоцроосон 16 хоршоо байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж байгаа байдлыг харуулбал дараах байдалтай байна.



Хоршоодын гишүүдийн тоог графикаар үзүүлбэл:



Хадгаламж, зээлийн хоршоодын тоо тайланд улиралд буурсан хэдий ч гишүүдийн тоо 212 гишүүнээр нэмэгдэж, нэг хоршоонд элссэн гишүүдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Харин 2011 оны нэгдүгээр улирлын байдлаар санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлээгүй 23 хоршооны нэгтгэлд хамруулсан санхүүгийн тайланг цаг хугацааны хувьд нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Тайлант хугацаа	ХЗХ-ны тоо	ХЗХ-дын нэрс
1	2009-III	1	Баянлхам
2	2009-IV	4	Очир төр, Дөргөн хөгжил, Манхан хөгжил, ЯАХ
3	2010-II	2	Рашааны далай, Ижил хүлэг
4	2010-III	4	Тонхил хөгжил, Ландо, Арвижих хас, Өргөн эрдэнэ
5	2010-IV	12	Говийн андууд, Онгийн харз, Монконкорд, Анхдагч андууд, Буянт богдын хишиг, Найдсэй, Цэнгэл хөгжил, Бэлүү хөгжил, Цогт жанчхүү, Говийн цог, Идэрийн ундарга, Дэлүүн бүргэд
Нийт		23	

Хорооны хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Онууд	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл					Хоршоодын тоо
	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	түдгэлзүүлснийг сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010	2	35	15	4	80	179
2011-I	2	3	2	-	8	178

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны I улирал	2010 оны I улирал
1	ХЗХ-дын тоо	178	207
2	Гишүүдийн тоо	26,202	27,132
3	Нийт актив /мян.төг/	50,697,885.9	44,269,760.3
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%	1.1%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	35,860,090.0	34,024,949.7
	Банкны салбарт эзлэх хувь	1.0%	1.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	2,996,415.7	3,165,385.6
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%	1.2%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	36,420,912.6	30,109,975.4
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	2.1%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төг/	7,660,162.0	7,401,896.7
	Банкны салбарт эзлэх хувь	3.1%	3.3%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл /мян.төг/	3,681,577.4	3,811,308.3
	Банкны салбарт эзлэх хувь	2.4%	1.1%
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	455,719.7	524,729.2
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	176,753.8	232,171.2
11	Нийт орлого /мян.төг/	3,345,132.0	3,360,033.8
12	Нийт зардал /мян.төг/	3,162,120.1	3,420,536.2
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	183,011.9	-60,502.4
14	Активын өгөөж /ROA/	16.9	*

15	Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	58.1	*
----	------------------------------	------	---

*-тооцох боломжгүй

2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны I улирал	2010 оны I улирал
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	74	88
2	Гишүүдийн тоо	11,401	12,261
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	<i>43.5%</i>	<i>45.2%</i>
3	Нийт актив /мян.төг/	43,643,677.4	38,118,301.7
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	<i>86.1%</i>	<i>86.1%</i>
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	30,479,307.4	29,121,737.7
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>85.0%</i>	<i>85.6%</i>
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	2,435,097.7	2,523,157.3
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>81.3%</i>	<i>79.7%</i>
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	33,065,399.4	27,299,033.7
	<i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>90.8%</i>	<i>90.7%</i>
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	5,337,285.4	5,289,337.3
	<i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>69.7%</i>	<i>71.5%</i>
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	3,159,312.3	3,487,921.3
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	<i>85.8%</i>	<i>91.5%</i>
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	54,600.0	83,229.3
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	8,986.3	77,915.4
11	Нийт орлого /мян.төг/	2,571,669.1	2,700,079.6
12	Нийт зардал /мян.төг/	2,580,794.4	2,939,322.2
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	- 9,125.3	-239,242.6

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 74 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 41.6 хувийг, тэдгээрийн нийт актив 43,643,677.4 мянган төгрөг байгаа нь нийт активын 86.1 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын тоо 14-өөр буурсан ч харин активын хэмжээ 5,525,375.7 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Эдгээр 74 хоршоод 2,571,669.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 76,9 хувийг, харин 2,580,794.4 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 81.6 хувийг тус тус эзэлж байна.

2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны I улирал	2010 оны I улирал
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	104	119
2	Гишүүдийн тоо	14,801	14,871
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	<i>56.5%</i>	<i>54.8%</i>
3	Нийт актив /мян.төг/	7,054,208.6	6,151,458.7
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	<i>13.91%</i>	<i>13.9%</i>
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	5,380,782.6	4,903,212.0
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>15.0%</i>	<i>14.4%</i>
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	561,318.0	642,228.2
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>18.7%</i>	<i>20.3%</i>
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	3,355,513.2	2,810,941.7
	<i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>9.2%</i>	<i>9.3%</i>
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	2,322,876.6	2,112,559.4
	<i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>30.3%</i>	<i>28.5%</i>

8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	522,265.1	323,386.9
	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	14.2%	8.5%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	401,119.7	441,499.9
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	167,767.6	154,255.8
11	Нийт орлого /мян.төг/	773,462.9	659,954.2
12	Нийт зардал /мян.төг/	581,325.7	481,214.0
13	Тухайн үеийн ашиг /мян.төг/	192,137.2	178,740.2

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 104 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 58.4 хувийг, тэдгээрийн нийт актив 7,054,208.6 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.9 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын тоо 15-аар буурсан ч активын хэмжээ 902,749.9 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Эдгээр 104 хоршоо нь 773,462.9 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 23.1 хувийг, харин 581,325.7 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 18.4 хувийг тус тус эзэлж байна.



2.3 Хасбанкны франчайзийн гэрээтэй ажиллаж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны I улирал	2010 оны I улирал
1	Хас банктай франчайзийн үйлчилгээний гэрээтэй ХЗХ-дын тоо	64	74
2	Гишүүдийн тоо	9,834	9,299
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	37.5%	34.3%
3	Нийт актив /мян.төг/	3,586,929.6	2,864,277.50
	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	7.1%	6.5%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	2,832,683.5	2,288,834.58
	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	7.9%	6.7%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	85,005.5	134,831.61
	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	2.8%	4.3%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	1,109,745.9	1,350,501.51
	ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	3.0%	4.5%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	1,433,142.1	1,513,775.98
	ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	18.7%	20.5%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	382,839.8	1,215,080.26
	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	10.4%	31.9%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	401,119.7	673,221.69
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	167,767.6	6,108.64
11	Нийт орлого /мян.төг/	525,935.8	396,088.29
12	Нийт зардал /мян.төг/	351,446.4	26,509.92
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	174,489.3	130,909.61

Хасбанктай франчайзийн гэрээтэй 64 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тайлант улиралд Хасбанкнаас үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа цаашид үйл ажиллагаа хэвийн

явуулах боломжгүй болсон Бидний хөтөч, Наранховаат хоршоодын хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчил арилаагүй шалтгаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагааг хүчингүй болгосон.

Франчайзийн гэрээтэй хоршоодын орлого, зарлагын тайлангаас харахад 525,935.8 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт орлогын 15.7 хувийг, харин 351,446.4 мянган төгрөгийн зардал нь нийт зардлын 11.1 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 174,489.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Орлогын үзүүлэлтүүд

Тайлант улиралд нийт орлогын хэмжээ 3,345,132.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14,901.8 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж гишүүдээс гадаад валютаар хадгаламж татан төвлөрүүлэх, гадаад валютаар зээл олгохыг хориглосонтой холбоотойгоор гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 213,997.9 мянган төгрөгөөр буюу 82.9 хувиар буурсантай холбоотой байна.

	Орлогын бүтэц дараах байдалтай байна. Үүнд		/мянган төгрөгөөр/		Өөрчлөлт	
	2011.03.31		2010.03.31		Дүн	ХУВЬ
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ОРЛОГО	3,082,974.7	92.2%	2,882,492.4	85.8%	200,482.3	7.0%
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	2,935,182.3	87.7%	2,725,983.2	81.1%	209,199.1	7.7%
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	41,963.6	1.3%	37,385.6	1.1%	4,578.0	12.2%
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	81,278.5	2.4%	82,138.7	2.4%	-860.2	-1.0%
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	1,276.6	0.0%	185.4	0.0%	1,091.2	0.0%
Бусад хүүгийн орлого	23,273.7	0.7%	36,799.4	1.1%	-13,525.7	-36.8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	150,933.4	4.5%	87,309.5	2.6%	63,623.9	72.9%
Элсэлтийн хураамж	4,478.5	0.1%	3,077.0	0.1%	1,401.6	45.5%
Гишүүний татвар	13,524.7	0.4%	11,496.3	0.3%	2,028.4	17.6%
Үйлчилгээний хураамж	41,837.0	1.3%	27,267.3	0.8%	14,569.7	53.4%
Үйл ажиллагааны бусад орлого	91,093.2	2.7%	45,468.9	1.4%	45,624.2	100.3%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	111,223.9	3.3%	390,231.9	11.6%	-279,008.0	-71.5%
Торгуулийн орлого	-	0.0%	100.0	0.0%	-100.0	-100.0%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	1,619.3	0.0%	4,266.7	0.1%	-2,647.4	-62.0%
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	-	0.0%	19,309.2	0.6%	-19,309.2	0.0%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	44,134.6	1.3%	258,132.5	7.7%	-213,997.9	-82.9%
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	19,007.7	0.6%	32,631.3	1.0%	-13,623.6	-41.8%
Бусад орлого	45,678.0	1.4%	44,235.4	1.3%	1,442.6	3.3%
Онцгой шинжтэй орлого	585.0	0.0%	31,542.7	0.9%	-30,957.7	-98.1%
Ердийн бус орлого	199.4	0.0%	14.1	0.0%	185.3	1309.7%
Нийт орлогын дүн	3,345,132.0	100.0%	3,360,033.8	100.0%	-14,901.8	-0.4%

Тайлант улиралд нийт орлогын 92.2 хувийг зээлийн хүүгийн орлого, 3.3 хувийг үйл ажиллагааны бус орлого, 4.5 хувийг элсэлтийн хураамж, гишүүний татвар, үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны бусад орлого эзэлж байна.

3.2 Зардлын үзүүлэлтүүд

Тайлант улиралд нийт зардлын хэмжээ 3,162,120.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 258,416.1 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан ба үүнд үйл ажиллагааны бус зардлын өөрчлөлт нөлөөлжээ.

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	1,839,767.1	58.2%	1,698,876.48	49.7%	140,890.6	8.3%
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	742,957.1	23.5%	734,665.08	21.5%	8,292.1	1.1%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	840,860.2	26.6%	794,974.30	23.2%	45,885.9	5.8%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	132,955.9	4.2%	115,824.90	3.4%	17,131.0	14.8%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	121,867.6	3.9%	51,781.32	1.5%	70,086.3	135.4%
Бусад хүүгийн зардал	1,126.1	0.0%	1,630.88	0.0%	-504.8	-31.0%
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	435,145.9	13.7%	437,473.92	12.8%	- 2,328.0	-0.5%
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	405,764.4	12.8%	435,724.81	12.7%	- 29,960.4	-6.9%
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	13,440.3	0.4%	85.91	0.0%	13,354.3	15544.8%
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	2,222.7	0.1%		0.0%	2,222.7	0
Бусад эрсдэлийн зардал	13,718.6	0.4%	1,663.20	0.0%	12,055.4	724.8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	761,489.7	24.1%	693,966.34	20.3%	67,523.4	9.7%
Боловсон хүчний зардал	470,436.0	14.9%	394,425.45	11.5%	76,010.6	19.3%
Бусад зардал	291,053.7	9.2%	299,540.89	8.8%	-8,487.2	-2.8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	125,717.4	4.0%	590,219.50	17.3%	-464,502.1	-78.7%
Торгуулийн зардал	1,213.7	0.0%	1,642.64	0.0%	-428.9	-26.1%
Ногдол ашгийн зардал		0.0%	7,948.38	0.2%	-7,948.4	-100.0%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	99.0	0.0%	107.93	0.0%	- 8.9	-8.3%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	69,326.6	2.2%	522,630.64	15.3%	- 453,304.1	-86.7%
Үйл ажиллагааны бус бусад зардал	4,617.1	0.1%	30,139.01	0.9%	- 25,521.9	-84.7%
Ердийн бус зардал	12.4	0.0%	111.15	0.0%	- 98.7	-88.8%
Татварын зардал	50,448.5	1.6%	27,639.75	0.8%	22,808.8	82.5%
Нийт зардлын дүн	3,162,120.1	100.0%	3,420,536.24	100.0%	- 258,416.1	-7.6%

Зардлын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон. Тухайлбал; хүүгийн зардлын нийт зардалд эзлэх хувийн жин 49.7-58.2 хувиар, боловсон хүчний зардал 11.5-14.9 хувиар, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 12.8-13.7 хувиар бусад зардал 8.8-9.2 хувиар тус тус өсч, харин үйл ажиллагааны бус зардал буюу гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал 15.3-2.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

3.3 Алдагдалтай ажиллаж буй хоршоод

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын 22.5 хувь буюу 40 хоршоо нийт 295,235.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.

д/д	Үзүүлэлтүүд	Хоршоодын тоо	Нийт алдагдал	Эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	1	205,215.2	69.5%
2	10,000.0-100,000.0 мянган төгрөг	3	32,705.2	11.1%
3	1,000.0-10,000.0 мянган төгрөг	13	50,868.3	17.2%
4	100.0-1,000.0 мянган төгрөг	17	6,136.2	2.1%

5	100.0 мянган төгрөг хүртэл	6	310.1	0.1%
	Нийт дүн	40	295,235.0	100.0%

Нийт алдагдалтай ажиллаж байгаа хоршоодын 50.0 хувь буюу 20 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн алдагдал 274,588.5 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 93.0 хувийг эзэлж байна.

Орон нутагт алдагдалтай ажиллаж байгаа 20 хоршооны 20,646.5 төгрөгийн алдагдал нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 7.0 хувийг, үүнээс, Хасбанктай франчайзийн гэрээтэй 14 хоршоо 5,028.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын нийт алдагдлын 24.4 хувийг эзэлж байна. Эдгээр хоршоодын зээлийн чанар муудсан нь алдагдалтай ажиллахад ихээр нөлөөлсөн.

3.4 Ашигтай ажиллаж буй хоршоод

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт хоршоодоос 137 хоршоо буюу 77.0 хувь нь 478,246.9 мянган төгрөгийн ашигтай, 1 хоршоо ашиг ч үгүй, алдагдал ч үгүй ажилласан байна.

Ашгийн хэмжээгээр хоршоодыг ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Ашгийн үзүүлэлтүүд	Хоршооны тоо	Нийт ашиг	Ашигт эзлэх хувь
1	10,000.0-50,000.0 мянган төгрөг	12	284,005.7	59.4%
2	5,000.0-10,000.0 мянган төгрөг	7	42,400.8	8.9%
3	1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	46	122,858.6	25.7%
4	1,000.0 мянган төгрөг хүртэл	72	28,981.9	6.1%
5	Ашиг, алдагдалгүй	1	0.0	0.0%
		138	478,246.9	100.0%

Нийт ашигтай ажиллаж байгаа хоршоодын 38.7 хувь буюу 53 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн ашиг 264,567.3 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 55.3 хувийг эзэлж байна.

Орон нутагт ашигтай ажиллаж байгаа 84 хоршооны ашиг 213,679.6 мянган төгрөг нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 44.7 хувийг, үүнээс Хасбанктай франчайзийн гэрээтэй 50 хоршоо нийт 179,517.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан хоршоодын нийт ашгийн 84.0 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын чанар

Хоршоодын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	49,404,382.5	97.4%	43,171,777.3	97.5%	6,232,605.2	14.4%


/мянган төгрөгөөр/

МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,352,129.5	24.4%	8,052,247.6	18.2%	4,299,881.9	53.4%
1.Касс дахь бэлэн мөнгө	1,654,788.6	3.3%	1,455,976.9	3.3%	198,811.7	13.7%
2.Банкинд байршуулсан харилцах	6,802,299.7	13.4%	3,851,731.8	8.7%	2,950,567.9	76.6%
3.Банкинд байршуулсан хадгаламж	3,895,041.2	7.7%	2,743,940.4	6.2%	1,151,100.8	42.0%
4.Бусад байгууллагад байршуулсан харилцах		0.0%	598.6	0.0%	(598.6)	0.0%
5.Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	-	0.0%	-	0.0%	-	0.0%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	33,381,463.5	65.8%	31,879,318.6	72.0%	1,502,144.9	4.7%
8. Нийт зээл	35,860,090.0	70.7%	34,024,949.7	76.9%	1,835,140.3	5.4%
8.1.Хэвийн зээл	31,524,179.3	62.2%	27,201,702.6	61.4%	4,322,476.7	15.9%
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	1,339,495.0	2.6%	3,657,861.6	8.3%	(2,318,366.6)	-63.4%
8.3.Чанаргүй зээл	3,165,385.6	6.2%	3,165,385.6	7.2%	-	0.0%
8.3.1. Хэвийн бус	377,022.0	0.7%	1,417,485.4	3.2%	(1,040,463.4)	-73.4%
8.3.2. Эргэлзээтэй зээл	595,146.7	1.2%	296,506.4	0.7%	298,640.3	100.7%
8.3.3. Муу зээл	2,024,247.1	4.0%	1,451,393.8	3.3%	572,853.3	39.5%
8.4.(Зээлийн эрсдэлийн сан)	2,478,626.6	4.9%	(2,145,631.1)	-4.8%	4,624,257.7	-215.5%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,919,772.3	5.8%	2,576,328.3	5.8%	343,444.0	13.3%
9. Байгууллага, хүмүүсээс авах авлага	325,414.0	0.6%	302,804.8	0.7%	22,609.2	7.5%
10. (Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрсдэлийн сан)	48,328.9	0.1%	42,690.1	0.1%	5,638.8	13.2%
11. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,642,687.1	5.2%	2,316,213.6	5.2%	326,473.6	14.1%
БУСАД ХӨРӨНГӨ	203,792.8	0.4%	170,464.8	0.4%	33,327.9	19.6%
12. Материал үнэ бүхий зүйл	126,109.6	0.2%	121,503.5	0.3%	4,606.1	3.8%
14. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	22,897.1	0.0%	16,107.1	0.0%	6,790.0	42.2%
15. Бусад актив	54,786.1	0.1%	32,854.2	0.1%	21,931.8	66.8%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	547,224.4	1.1%	493,417.9	1.1%	53,806.5	10.9%
16. Өмчлөх бусад хөрөнгө	612,628.3	1.2%	540,935.0	1.2%	71,693.2	13.3%
17. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан)	65,403.9	0.1%	47,517.1	0.1%	17,886.7	37.6%
2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,293,503.5	2.6%	1,097,983.0	2.5%	195,520.5	17.8%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,187,152.8	2.3%	989,424.0	2.2%	197,728.8	20.0%
18. Үндсэн хөрөнгө	1,624,829.2	3.2%	1,459,091.6	3.3%	165,737.6	11.4%
19.(Үндсэн хөрөнгийн элэгдэл)	437,676.5	0.9%	469,667.7	1.1%	(31,991.2)	-6.8%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	106,350.7	0.2%	108,559.1	0.2%	(2,208.4)	-2.0%
20. Биет бус хөрөнгө	21,394.0	0.0%	30,023.5	0.1%	(8,629.5)	-28.7%
21.Бусад	84,956.7	0.2%	78,535.5	0.2%	6,421.2	8.2%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	50,697,885.9	100.0%	44,269,760.3	100.0%	6,428,125.6	14.6%

Тайлант улиралд активын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс эх үүсвэр 6,428,125.6 мянган төгрөг буюу 14.6 хувиар нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал; Эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн хэдий ч чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн нийт активт эзлэх хувийн жин 7.2-6.2 хувиар, нийт зээлийн хэмжээ 1,835,140.3 мянган төгрөгөөр буюу 76.9-70.7 хувиар буурсан. Харин банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн хэмжээ 18.2-24.4 хувь хүртэл өссөн байна.

Харин хоршоодын активын бүтцийг авч графикаар харуулбал дараах байдалтай байна.



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Активын хэмжээ	Хоршоодын тоо	Нийт актив	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	20,156,490.9	39.8%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	5	14,110,746.4	27.8%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	10	5,986,728.0	11.8%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	36	6,723,487.8	13.3%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	25	1,806,124.8	3.6%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	74	1,755,236.8	3.5%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	16	119,688.9	0.2%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	11	39,382.2	0.1%
	Нийт дүн	178	50,697,885.9	100.0%

Активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш активтай нийт 16 хоршооны нийт актив 40,253,965.3 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт активын 79.4 хувийг эзэлж байна.

Дээрх томоохон активтай 16 хоршооноос Номин юнион, Монкорд, Сидан, Май капитал, Есөн дэлбээ, Кредит юнион монгол, Финком, Монум, Мон сант алдар, Очир ундраа инвест Монгол газар гоулд, Цэнгэл хөгжил, Байтерик зэрэг 13 хоршоо тайлант улиралд 219,220.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт ашгийн 45.8 хувийг, Алтан давалгаа, Зоосон мөнгө, Завхан нөхөрлөл зэрэг 3 хоршоо 211,397.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт алдагдлын 71.6 хувийг тус тус эзэлж байна.

4.2 Зээлийн багцын чанар

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/


ҮЗҮҮЛЭЛТ	2011.03.31		2010.03.31		ӨӨРЧЛӨЛТ	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	33,381,463.5		31,879,318.6		1,502,144.9	4.7%
Нийт зээл	35,860,090.0	100.0%	34,024,949.7	100.0%	1,835,140.3	5.8%
Хэвийн зээл	31,524,179.3	87.9%	27,201,702.57	79.9%	4,322,476.7	13.6%
Хугацаа хэтэрсэн зээл	1,339,495.0	3.7%	3,657,861.60	10.8%	(2,318,366.6)	-7.3%
Чанаргүй зээл	2,996,415.7	8.4%	3,165,385.56	9.3%	(168,969.8)	-0.5%

Хэвийн бус	377,022.0	1.1%	1,417,485.44	4.2%	(1,040,463.4)	-3.3%
Эргэлзээтэй зээл	595,146.7	1.7%	296,506.37	0.9%	298,640.3	0.9%
Муу зээл	2,024,247.1	5.6%	1,451,393.76	4.2%	572,853.3	1.8%
(Зээлийн эрсдэлийн сан)	2,478,626.6		2,145,631.12		332,995.4	1.0%

Тайлант улиралд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,835,140.3 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2,318,366.6 мянган төгрөг буюу 7.3 хувиар буурч нийт зээлийн багцын 10.8-3.7 хувийг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 168,969.8 мянган төгрөг буюу 0.5 хувиар буурч, нийт зээлийн багцын 9.3-8.4 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн багцыг графикаар харуулбал:



Зээлийн багцын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт 1,835,140.3 мянган төгрөг буюу 5.8 хувиар өссөн. Харин зээлийн болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээ нийт актив хөрөнгийн 4.9 хувийг эзэлж байна.

Хоршоодын зээлийн өрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Зээлийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт зээлийн үлдэгдэл	Нийт зээлд эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	13,673,895.6	38.1%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	3	7,665,623.5	21.4%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	7	4,796,329.7	13.4%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	28	5,690,518.8	15.9%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	30	2,237,391.0	6.2%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	71	1,606,723.3	4.5%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	18	126,678.7	0.4%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	20	62,929.4	0.2%
	Нийт зээлийн өрийн үлдэгдлийн дүн	178	35,860,090.0	100.0%

Зээлийн өрийн үлдэгдлийг ангилахад ихээхэн хэмжээний буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй нийт 11 хоршооны зээлийн өрийн үлдэгдэл 26,135,848.8 мянган төгрөг байгаа нь нийт хоршоодын олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 72.9 хувийг эзэлж байна.

ТАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Хоршоодын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Тухайлбал;

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.03.31		2010.03.31		Өөрчлөлт	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
1. ӨР ТӨЛБӨР	39,356,146.6	77.6%	33,056,555.3	74.7%	6,299,591.2	-10.9%
ХАДГАЛАМЖ	36,420,912.6	71.8%	30,109,975.4	68.0%	6,310,937.1	21.0%
1. Хугацаагүй	1,752,262.4	3.5%	1,739,815.2	3.9%	12,447.2	0.7%
2. Хугацаатай	34,668,650.2	68.4%	28,370,160.3	64.1%	6,298,489.9	22.2%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	455,719.7	0.9%	524,729.2	1.2%	- 69,009.5	-13.2%
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	355,693.7	0.7%	522,481.0	1.2%	-166,787.3	-31.9%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	100,026.0	0.2%	2,248.2	0.0%	97,777.8	4349.2%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,302,760.5	4.5%	2,189,679.5	4.9%	113,080.9	5.2%
5. Татварын төлөх өглөг	81,417.6	0.2%	47,357.4	0.1%	34,060.2	71.9%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,040,887.4	4.0%	1,830,237.0	4.1%	210,650.3	11.5%
7. Өглөг	109,400.1	0.2%	156,416.4	0.4%	- 47,016.3	-30.1%
8. Бусад пассив	71,055.4	0.1%	155,668.7	0.4%	- 84,613.3	-54.4%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	176,753.8	0.3%	232,171.2	0.5%	- 55,417.4	-23.9%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	173,683.0	0.3%	232,171.2	0.5%	- 58,488.2	-25.2%
9. Урт хугацаат төслийн санхүүжилт	3,070.9		-			
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	11,341,739.4	22.4%	11,213,205.0	25.3%	128,534.4	0.1%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,660,162.0	15.1%	7,401,896.7	16.7%	258,265.3	3.5%
10. Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,660,162.0	15.1%	7,401,896.7	16.7%	258,265.3	3.5%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	3,681,577.4	7.3%	3,811,308.3	8.6%	- 129,730.8	-3.4%
11. Нөөцийн сан	1,696,878.0	3.3%	1,439,962.5	3.3%	256,915.5	17.8%
12. Дахин үнэлгээний сан	268,559.8	0.5%	89,614.0	0.2%	178,945.8	199.7%
13. Нийгмийн хөгжлийн сан	250,845.1	0.5%	198,543.2	0.4%	52,301.9	26.3%
14. Бусад сангууд	120,909.5	0.2%	126,244.3	0.3%	- 5,334.8	-4.2%
15. Хандив, тусламж	43,257.6	0.1%	46,785.9	0.1%	- 3,528.3	-7.5%
16. Бусад өмч	270,096.4	0.5%	19,963.0	0.0%	250,133.4	1253.0%
17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	183,011.9	0.4%	(60,502.4)	-0.1%	243,514.3	-402.5%
18. Хуримтлагдсан ашиг/алдагдал	848,019.2	1.7%	1,950,697.9	4.4%	- 1,102,678.7	-56.5%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	50,697,885.9	100.0%	44,269,760.3	100.0%	6,428,125.6	-10.8%

Тайлант улиралд өмнөх оны мөн үеэс гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,310,937.1 мянган төгрөгөөр буюу 21.0 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 258,265.3 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар өссөн бол хоршоологчдын өмчийн хэмжээ 129,730.8 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хоршоологчдын өмчийн бууралтад өмнөх үеийн хуримтлагдсан ашгийн хэмжээ 1,102,678.7 мянган төгрөгөөр, бусад сан 5,334.8 мянган төгрөгөөр, хандив тусламж 3,528.3 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн. Харин хугацаатай хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 6,298,489.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Харин банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл, урт хугацаат өр төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 69,009.5 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар, урт хугацаат өр төлбөр 55,417.4 мянган төгрөгөөр буюу 25.2 хувиар тус тус буурчээ.

Хоршоодын татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Хадгаламжийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт хадгаламжийн үлдэгдэл	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	16,111,713.1	44.2%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	2	9,718,457.5	26.7%

3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	5	3,542,305.7	9.7%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	22	4,746,464.4	13.0%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	15	1,045,076.8	2.9%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	47	1,074,382.6	2.9%
7	1,000.0-10,000.0 мянган төгрөг	40	175,015.7	0.5%
8	1,000.0 мянган төгрөг хүртэл	20	7,496.8	0.0%
9	Хадгаламжгүй	26	0.0	0.0%
	Нийт дүн	178	36,420,912.6	100.0%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 8 хоршооны татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 29,372,476.3 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хадгаламжийн үлдэгдлийн 80.6 хувийг эзэлж байна.

Харин гишүүдээсээ хадгаламж татан төвлөрүүлээгүй 26 хоршоо буюу нийт хоршоодын 14.6 хувь нь зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Хувь нийлүүлсэн хөрөнгө тайлант улиралд 7,660,162.0 мянган төгрөг байгаа бөгөөд интервалаар харуулбал дараах байдалтай байна.


д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	ХНХ-ийн хэмжээ	Нийт ХНХ-ийн хэмжээнд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	2,059,131.1	0.3
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	8	2,014,350.1	0.3
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	18	1,166,550.4	0.2
4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	55	1,666,014.1	0.2
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг	32	400,784.9	0.1
6	5,000.0-10,000.0 мянган төгрөг	33	251,505.1	0.0
7	1,000.0-5,000.0 мянган төгрөг	31	101,826.3	0.0
	Нийт дүн	178	7,660,162.0	1.0

Салбарын хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2010 оны жилийн эцэст 7,357,425.1 мянган төгрөг байсан бол 2011 оны эхний улиралд 302,736.9 мянган төгрөгөөр, өмнөх оны мөн үеийн байдлаас 258,265.3 мянган төгрөгөөр тус тус өсчээ. Тайланд улиралд хувь нийлүүлсэн хөрөнгө 7.7 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын 3.1 хувийг эзэлж байна.

Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 2007-2011 оны нэгдүгээр улирлыг хүртэлх өөрчлөлтийг харуулбал дараах байдалтай байна.



Харин хадгаламж, зээлийн хоршоодын системийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг интервалаар харуулбал дараах байдалтай байна.



Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2,1 тэрбум төгрөг буюу нийт хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн 27.0 хувийг Номин юнион хадгаламж, зээлийн хоршоо, 10,0 сая хүртэл төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 64 хоршоо, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 0,4 тэрбум төгрөг буюу 5,0 хувь, 10,0-100,0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 105 хоршоо, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 3,2 тэрбум төгрөг буюу 42.0 хувийг, 100-500,0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 8 хоршоо, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2,0 тэрбум төгрөг буюу нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 26.0 хувийг эзэлж байна.

Харин хадгаламж, зээлийн хоршоодын хоршоологчдын өмчийн бүтэц дараах байдалтай байна.

д/д	Хоршоологчдын өмч	Хоршооны тоо	Хоршоологчдын өмчийн дүн	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	800,000.0 мянган төгрөгөөс дээш	1	818,828.3	22.2%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	7	1,746,548.3	47.4%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	5	292,758.0	8.0%
4	10,000.0-50,000.0 мянган төгрөг	36	919,371.2	25.0%
5	1,000.0-10,000.0 мянган төгрөг	80	343,670.2	9.3%
6	1,000.0 мянган төгрөг хүртэл	20	8,623.4	0.2%
7	Хоршоологчдын өмчгүй /алдагдал ихтэй/	29	-448,221.9	-12.2%
	Нийт дүн	178	3,681,577.4	100.0%

Номин юнион хоршооны хоршоологчдын өмч 0.8 тэрбум төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хоршоологчдын өмчийн 22.2 хувийг, 100.0-500.0 сая төгрөг хүртэл хоршоологчдын өмчтэй Очир ундраа инвест, Монгол газар гоулд, Есөн дэлбээ, Монкорд, Сидан, Мон сант алдар, Их наяд кредит зэрэг 7 хоршооны хоршоологчдын өмчийн хэмжээ 1.7 тэрбум төгрөг буюу нийт хоршоодын хоршоологчдын өмчийн 47.4 хувийг эзэлж байна.

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Үүнд:

/мянган төгрөгөөр/

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД			ТАЙЛАНГААР
А АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН			
1	АКТИВЫН ЭРСДЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	2,483,050.6	2,478,626.6 Дутуу байгуулсан
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	8.4% Хангаагүй
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош)	30.0%	0.0%
Б ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80%	65.8%
5	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	1.1%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	2.3%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0%	71.8%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0%	1.0%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	15.1%
10	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0%	7.3% Хангаагүй
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	552,236.6	1,696,878,0
В ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ			
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	1.5%
Г ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР			
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	22.8%
Д ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)			
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		0.5%
16	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		16.1%
17	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		8.5%

Хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн хувьд активын эрсдлийн санг 4,424.0 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, чанаргүй зээлийн зохистой харьцаа 3.4 хувиар хангагдаагүй, гишүүдийн хоршоологчдын өмчийн харьцааг хангаагүй байна. Харин бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

ДОЛОО. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР


Хорооноос хадгаламж, зээлийн хоршоодод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй хоршоодыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээгээр нь 4 ангилж дараах байдлаар бүлэглэсэн. Үүнд:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах ХЗХ тоо	Эзлэх хувь	ХЗХ-ны тоо	
				УБ хотод	Орон нутагт
1	50.0 сая төгрөг хүртэл	101	56.7	32	69
2	50-500.0 сая төгрөг	61	34.3	29	32
3	500.0-1.0 тэрбум төгрөг	10	5.6	7	3
4	1.0 тэрбумаас дээш	6	3.4	6	-
Нийт дүн		178	100.0	74	104

Бодит үнэлгээ өгөхийн тулд бүлэг тус бүрээр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож гаргасан.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2011 оны нэгдүгээр улиралд 178 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хоршоодын орон нутгийн байршлыг графикаар харуулбал:



Хадгаламж, зээлийн хоршоодын тоо тайланд онд буурсантай холбоотойгоор гишүүдийн тоо 212 гишүүнээр буурсан хэдий ч нэг хоршоонд элссэн гишүүдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 2010 оны зохицуулалт үйлчилгээний хөлс 13,065.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 2011 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 10,844.5 мянган төгрөг буюу 83.0 хувийг Хорооны төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдээсээ татан төвлөрүүлсэн хадгаламж болон олгосон зээлийн хэмжээ байнгын өсөлттэй байгаа бөгөөд 2011 оны нэгдүгээр улиралд гишүүдээсээ татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл 36.4 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын 1.2 хувийг, зээлийн өрийн үлдэгдэл 35.9 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.

2007-2011 оны нэгдүгээр улирлын байдлаарх хоршоодын хадгаламж, зээлийн талаарх мэдээллийг графикаар харуулбал дараах байдалтай байна.



2011 оны нэгдүгээр улирлын байдлаар хадгаламж, зээлийн хоршоодын салбарын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр нийт актив 50.7 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын 0.8 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн активын өсөлтийг дараах графикаас харж болохоор байна.



Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэж буй хоршоодоос 155 буюу нийт хоршооны 87.1 хувь нь зохих журмын дагуу 2011 оны нэгдүгээр улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн бөгөөд хариуцсан хянан шалгагчид нийт 145 хоршоонд буюу ирүүлсэн тайлангийн 93,5 хувийг хянан шалгаж 2011 оны 4 дүгээр сарын байдлаар тайлангийн хариуг хүргүүлсэн байна.

Иймд 2011 оны 2 дугаар улиралд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, мэдээгээ журмын дагуу гаргаж цаг хугацаандаа ирүүлдэггүй, 2 ба 3 улирал дараалан санхүүгийн тайлан ирүүлээгүй хоршоодын үйл ажиллагааг Хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын дагуу арга хэмжээ авч, журмын биелэлтэд анхаарч ажиллах;
2. Хоршооноос ирүүлж буй улирлын санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах, гишүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хоршооны дарга, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон нягтлан бодогч, зээлийн мэргэжилтнээр мэргэжлийн, ур чадвартай хүмүүсийг авч ажиллуулж байгаад анхаарах, тэдгээрт тавих шаардлагыг нэмэгдүүлэх, Монголын хоршоодын холбоо, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвтэй хамтран холбогдох сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах;

3. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны эрх зүйн үндэсийг боловсронгуй болгохтой холбогдуулан хуулийн төслийг хэлэлцэн батлуулахад анхаарч ажиллах;
4. Шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох заавар, журмуудыг шинэчлэн боловсруулах, боловсронгуй болгох;
5. Газар дээрх болон зайнаас тавих хяналтын чанар үр нөлөөг сайжруулахад анхаарч ажиллах;
6. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх;
7. Мэдээллийн баазыг шинэчлэх;
8. Активын ангилалаар 500,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээтэй буюу Бүлэг-3, Бүлэг-4-д хамрагдаж буй 13 хоршооны 2011 оны нэгдүгээр улирлын тайланг цахим хэлбэрээр дахин авч, программын ажиллагаанд тест хийж, бүрэн нэвтрүүлэхэд анхаарч ажиллах;